

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20 24 оны 07 сарын 16 өдөр

№ R-2024-34

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг
эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хороо ("СЗХ")-ны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын 2.2 дахь хэсэг, ХасБанк ХК ("Банк")-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл ("ТУЗ")-ийн 2024 оны 7 дугаар сарын 08-16-ны өдрийн хооронд хийсэн цахим санал хураалтын үр дүнд дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

- ТУЗ нь 2024 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн R-2024-33 дугаар тогтоолоор хагас жилийн ногдол ашиг зарлан хуваарилахыг хувьцаа эзэмшигчдэд зөвлөмж болгосныг;
- Банкны Дүрмийн 8.6 (ii)-д зааснаар ногдол ашиг хуваарилах шийдвэр нь стратегийн асуудал тул хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэхийг; мөн
- Хагас жилийн ногдол ашиг зарлан хуваарилах асуудлыг эцэслэн батлах болон холбогдох бусад шийдвэрийг гаргуулах зорилгоор Банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалт хэлбэрээр, цахимаар зохион байгуулах нь зүйтэй гэж Банкны ТУЗ үзсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- Банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал ("ХЭЭБХ")-ыг эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулсугай.
- ХЭЭБХ Зохион байгуулах комиссын даргаар Банкны Ерөнхий аудитор Э.Ундармааг томилсугай. Тус комиссын гишүүдийг холбогдох дотоод журмын дагуу томилохыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд үүрэг болгосугай.
- ХЭЭБХ-ын мэдэгдлийг 2024 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн дотор СЗХ болон Монголын Хөрөнгийн Бирж ("МХБ")-д хүргүүлэхийг ТУЗ-ийн Ажлын албанд даалгасугай.
- ХЭЭБХ зохион байгуулах тухай зар мэдээг МХБ-ийн цахим хуудас, өдөр тутмын сонин, Банкны албан ёсны веб сайт (www.xacbank.mn), сошиал орчин дахь албан ёсны хаягаар болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2024 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн дотор нийтэд мэдээлж, зарын давталтыг тийнхүү нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх зарласан хэлбэрээр дахин нэг удаа нийтэд мэдээлэхийг Зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

5. Эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулж буй ХЭЭБХ-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 8 дугаар сарын 08-ны өдөр байхаар тогтоосугай.
6. ХЭЭБХ-аар шийдвэрлэх асуудлын жагсаалт, гаргах шийдвэрийн төсөл, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2024 оны 7 дугаар сарын 24-ний өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлэхийг Зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
7. ХЭЭБХ-аар шийдвэрлэх асуудлыг 1 дүгээр хавсралтаар, ХЭЭБХ-аар шийдвэрлэх асуудалтай холбоотой баримт бичгийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар, Тооллогын комиссын бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралтаар, саналын хуудсыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчид шийдвэрлэх асуудалтай холбоотой баримт бичигтэй ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулагдсан ХасМийтинг аппликейшнээр дамжуулан танилцах боломжийг хангаж ажиллахыг Зохион байгуулах комисст даалгасугай.
9. Хувьцаа эзэмшигчдэд саналыг 2024 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 9:00 цагаас эхлэн 2024 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 16:00 цаг хүртэлх хугацаанд ХасМийтинг аппликейшнээр дамжуулан цахим хэлбэрээр авах боломжийг бүрдүүлэн ажиллахыг Зохион байгуулах комисст даалгасугай.
10. Эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулж буй ХЭЭБХ-аас гарсан шийдвэр, бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд МХБ, СЗХ-д хүргүүлэхийг ТУЗ-ийн Ажлын албанд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ